



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
 ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/162


Шивээговь сум

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн “Сумын 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Сумын 2021 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Өвсний фонд бүрдүүлэх” ажлын санхүүжилтад 11300000 /арван нэгэн сая гурван зуун мянга/-н төгрөгийг зарцуулсугай.
2. “Өвсний фонд бүрдүүлэх” ажлын санхүүжилтад зарцуулагдах 11300000 /арван нэгэн сая гурван зуун мянга/-н төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч /М.Энхжаргал/-д зөвшөөрсүгэй.
3. Дээрх ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Отгонжаргал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ